

РАДИО, ТЕЛЕВИЗҮҮДЭЭР НЭВТРҮҮЛЖ БАЙГАА СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНД ХЯНАЛТ ТАВЬЖ БАЙНА

СУРТАЛЧИЛГААНЫ ЭХНИЙ 7 ХОНОГИЙН МЭДЭЭ

Хяналтад хамрагдсан хугацаа: **2024.06.10-06.16-ны өдөр**

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.22-т заасан чиг үүргийн хүрээнд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа радио, телевизийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй нийт **119 телевиз, 56 радиогийн хөтөлбөрт** хуульд заасан үзүүлэлтээр Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сурталчилгаанд хяналт, мониторинг хийх техникийн боломжийг бүрдүүлж ажиллалаа.

Дээрх **175** радио, телевизээс Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.9-т заасны дагуу сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх хүсэлт, мэдэгдлийг нийт **83** телевиз, **42** радио ирүүлж, сурталчилгаа нэвтрүүлэхээр бүртгүүлсэн.

Орон нутгийн радиогийн хөтөлбөрийг гомдлоор хянахаар бичлэг хийж байгаа бол бусад телевиз радиогийн хөтөлбөрт хуульд заасан үзүүлэлт тус бүрээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрхтэй эсэхээс үл хамааран хяналт мониторинг хийж, тайлан мэдээг гарган ажиллаж байна.

1. Сонгуулийн сурталчилгаа эхэлснээс хойш 2024.06.10-06.16-ны өдрүүдэд радио, телевизүүдээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн байдал:

Хүснэгт 1. Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн телевизийн тоо

Тусгай зөвшөөрлийн ангилал	Тусгай зөвшөөрлийн тоо/ Хяналтад тоо	Сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий радио, телевизүүд	Сурталчилгаа нэвтрүүлсэн радио, телевиз							Нийт
			06.10.	06.11	06.12	06.13	06.14	06.15	06.16	
Өргөн нэвтрүүлгийн телевиз	18/18	17	17	17	16	17	17	16	16	17
Арилжааны телевиз	53/50	24	15	18	20	18	16	14	14	21
Орон нутгийн телевиз	48/37¹	42	14	17	22	18	22	23	22	24
Радио -УБ	31/31	24	7	7	8	7	8	13	18	18
Радио - Орон нутаг	25/24	18	Бичлэгээр							
	175*	125	Нийт сурталчилгаа нэвтрүүлсэн радио, телевизийн тоо 62 ТВ, 18 радио							80

*МҮОНРТ-ийн телевизийн 5 суваг, радиогийн 4 суваг дээрх тоонд ороогүй хэдий ч Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасан үзүүлэлтээр мөн хяналт тавьж байна.

¹ Хардаар 4 ТВ-н бичлэг ирж хянагдана, 1 ТВ-н (тэнгэр тв орхон) эфир техникийн шалтгаанаар тог зогссон. 6 ТВ сурталчилгаа нэвтрүүлэхгүй үйл ажиллагаа зогссон.

Сурталчилгааны эхний 7 хоногт сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхээр бүртгүүлсэн эрх бүхий **83** телевиз, **24** радиогоос нийт **62** телевиз, **18** радиогоор сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн бөгөөд сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхээр бүртгүүлсэн эрх бүхий **21** телевиз, **6** радио сурталчилгаа нэвтрүүлээгүй байна.

Орон нутгийн радиогийн хувьд: Орон нутагт тусгай зөвшөөрөлтэй нийт 25 ФМ радиогоос 1 радио Төрөлх Алтай ФМ-89.4 үйл ажиллагаагаа эхлээгүй байгаа бол Дорноговь-Бизнесийн хөтөч FM-89.16, Орхон-Эгшиг радио FM-89.1, Өмнөговь- Миний говь FM-89.1, Хөвсгөл-Тариалан сум-ФМ 89.5, Багануур гэр бүлийн радио FM-104.5 зэрэг 5 радио сонгуулийн сурталчилгааны явцад үйл ажиллагаагаа түр зогсоосон байна.

Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрхтэй 18 радиогоос Архангайн Анир ФМ 89.5 гэмтлийн улмаас эфир зогссон байна.

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ - Эрдэнэт долгион FM-107.1 сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхээр бүртгүүлээгүй, нэвтрүүлэхгүй болно.

2. Сурталчилгаа нэвтрүүлэх эрхгүй радио, телевизээр сурталчилгаа нэвтрүүлсэн эсэх:

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.10-т “Энэ хуулийн 46.9-д заасны дагуу бүртгүүлсэн радио, телевиз сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрхтэй бөгөөд бүртгүүлээгүй радио, телевизээр сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэхийг хориглоно” гэж заасан байдаг.

Гэвч сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх тухай мэдэгдлийг Харилцаа холбооны зохицуулах хороонд хуульд заасан хугацаанд ирүүлж бүртгүүлээгүй буюу сонгуулийн сурталчилгаа явуулах эрхгүй 1 арилжааны телевизээр 2024 оны 06-р сарын 14-ний өдөр 17:03:35 цагаас 17:06:04 цагийн хооронд нийт **00:02:29 минутын сонгуулийн сурталчилгааны хэсгийг нэг удаа** нэвтрүүлсэн байгаа нь хяналт, мониторингд бүртгэгдсэн.

Иймд Улаанбаатар хотод тусгай зөвшөөрөлтэй “Буган соёл” ХХК-ийн “Хөх монгол” телевизэд дээрх хуулийн 46.24-т заасны дагуу албан бичгээр Сануулах арга хэмжээ авсан.

Улаанбаатар хот болон орон нутгийн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрхгүй радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн өөр зөрчил бүртгэгдээгүй.

3. Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн радио, телевизийн тухайд:

- Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн нийт **62** телевизээр нам, эвсэл, нэр дэвшигчид хамаарах **138:24:00** цагийн сурталчилгааны нэвтрүүлэг, **05:20:03** цагийн сурталчилгааны шторк, нийт **143:44:03** цагийн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн байна.

Хүснэгт 2. Телевизүүдээр нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааны цаг

№	он сар өдөр	ТВ-ийн тоо	Нэвтрүүлэг (цагаар)	Реклам (цагаар)	Нийт (цагаар)
1	2024.06.10	32 (17 ӨНТВ, 15 АрТВ)	17:28:04	0:02:29	17:30:33
		8 Орон нутгийн ТВ	1:18:52	0:32:31	1:51:23
2	2024.06.11	32 (17 ӨНТВ, 15 АрТВ)	15:11:51	0:02:51	15:14:42
		17 Орон нутгийн ТВ	3:16:14	0:43:05	3:59:19

3	2024.06.12	31 (17 ӨНТВ, 14 АрТВ)	15:47:58	0:06:35	15:54:33
		22 Орон нутгийн ТВ	5:09:47	0:37:56	5:47:43
4	2024.06.13	32 (17 ӨНТВ, 15 АрТВ)	16:15:17	0:10:24	16:25:41
		18 Орон нутгийн ТВ	4:20:36	0:37:51	4:58:27
5	2024.06.14	33 (17 ӨНТВ, 16 АрТВ)	9:02:27	0:10:01	9:12:28
		23 Орон нутгийн ТВ	5:39:11	0:38:59	6:18:10
6	2024.06.15	31 (17 ӨНТВ, 14 АрТВ)	12:13:44	0:09:57	12:23:41
		22 Орон нутгийн ТВ	5:42:32	0:44:08	6:26:40
7	2024.06.16	32 (17 ӨНТВ, 15 АрТВ)	21:52:02	0:07:50	21:59:52
		22 Орон нутгийн ТВ	5:05:25	0:35:26	5:40:51
Нийт цаг			138:24:00	5:20:03	143:44:03



Телевизээр нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааг төрлөөр нь авч үзэхэд 96.12 хувийг сурталчилгааны нэвтрүүлэг, 3.82 хувийг реклам тус тус эзэлж байна.

- Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн нийт 18 радиогоор нам, эвсэл, нэр дэвшигчид хамаарах 03:03:09 цагийн сурталчилгааны нэвтрүүлэг, 10:36:59 цагийн сурталчилгааны шторк, нийт 13:40:08 цагийн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн байна.

Хүснэгт 3. Радиогоор нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааны цаг

№	Сурталчилгаа нэвтрүүлсэн өдөр	Радиогийн тоо	Нэвтрүүлэг (цагаар)	Реклам (цагаар)	Нийт (цагаар)
1	2024.06.10	7	2:08:15	0:03:02	2:11:17
2	2024.06.11	7	0:00:00	1:59:16	1:59:16
3	2024.06.12	8	0:00:00	3:10:51	3:10:51
4	2024.06.13	7	0:54:54	2:15:56	3:10:50
5	2024.06.14	8	0:00:00	3:07:54	3:07:54
6	2024.06.15	13	0:51:03	4:04:18	4:55:21
7	2024.06.16	18	0:44:50	5:56:50	6:41:40
Нийт цаг			4:39:02	20:38:07	25:17:09



Улаанбаатар хотын радиоогоор нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааны **18.39** хувийг нэвтрүүлэг, **81.61** хувийг сурталчилгааны реклам (шторк) тус тус эзэлсэн байна.

4. Радио, телевизүүдийн хөтөлбөрт хуульд заасан зөрчил бүртгэгдсэн эсэх:

РАДИО, ТЕЛЕВИЗЭЭР НЭВТРҮҮЛСЭН СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ МОНИТОРИНГИЙН ДҮН

Мониторингд хамрагдсан хугацаа: 2024.06.10-2024.06.17

Хүснэгт 4. Сонгуулийн сурталчилгааны хяналт, мониторингийн нэгдсэн дүн

№	Хяналт тавьсан үзүүлэлт	Улаанбаатар			Орон нутаг
		ӨН Телевиз	Ар Телевиз	Радио	Телевиз
1	Эх сурвалжийг дурдаагүй нэвтрүүлэг (Хуулийн 39.4)	-	-	-	-
2	Сурталчилгааг хоногт 1 цаг /60 минут/- аас хэтрүүлсэн эсэх (Хуулийн 46.6)	-	-	-	-
3	Нэг нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сурталчилгааны хугацаа хоногт 15 минутаа с хэтэрсэн эсэх: (Хуулийн 46.7)	-	-	-	1 ТВ
4	Мэдээ: Нам, эвсэл, нэр дэвшигчийн мэдээг хоногт 5 минутаас хэтрүүлсэн эсэх (Хуулийн 46.14)	-	3 ТВ	-	1 ТВ
5	Нам, эвслийн дарга, нэр дэвшигч оролцсон энэ хуульд зааснаас бусад хэлбэрийн бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, ярилцлага нэвтрүүлсэн эсэх (Хуулийн 48.10)	-	14 ТВ	16 (Дуу)	7 ТВ
7	Радио, телевизийн хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн дундуур сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхгүй байх. (Хуулийн 46.28)	-	-	-	-

Нэгдсэн дүнгээр: МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн сурталчилгааны эхний 7 хоногийн хяналт, мониторингийн дүн, мэдээгээр Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа Монгол Улсад хамрах хүрээтэй өргөн нэвтрүүлгийн 17 телевиз сонгуулийн

сурталчилгаа нэвтрүүлэхдээ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн дээрх заалтын ямар ч зөрчил гаргаагүй байна.

Хуулийн үзүүлэлт тус бүрээр гаргасан хяналт, мониторингийн дүн мэдээ

1. Сонгуулийн сурталчилгааны аливаа материалын баруун доод хэсэгт сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг тодорхой харагдахуйц байдлаар бичээгүй, эх сурвалжийг дурдаагүй сурталчилгааны нэвтрүүлэг гаргасан зөрчил радио, телевизэд бүртгэгдээгүй.
2. Сурталчилгааг хоногт **1 цаг /60 минут/-**аас хэтрүүлсэн зөрчил (**Хуулийн 46.6**)- ямар ч радио, телевизэд бүртгэгдээгүй.
3. **Хоногт гарах нэг нам, эвсэл, бие даан нэр дэвшигчид ногдох 15 минутыг хэтрүүлсэн эсэх мэдээлэл:**

Хүснэгт 5. Сурталчилгааны 15 минутын хэтрэлт бүртгэгдсэн байдал

№	Огноо	Хэтрэлт бүртгэгдсэн тоо	Хэтрэлт бүртгэгдсэн телевиз	Тайлбар
1	06-р сарын 10, 14, 15-ны өдрүүдэд	Орон нутгийн 1 ТВ	Завхан аймгийн Air 1	Орон нутгийн ТВ-ийн хувьд нэвтрүүлгийн давталт гарсан.
2	06-р сарын 11, 12, 13, 16-ны өдрүүд	Зөрчилгүй	-	-

Иймд дээрх телевизийн бүртгэгдсэн 15 минутын хэтрэлтийг хуулийн 46.24-т заасны дагуу мэдэгдэж, анхааруулга, зөвлөмж өгч ажиллалаа.

- Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа, сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн нийт 18 радиогийн хувьд хэтрэлт бүртгэгдээгүй.
4. **Радио, телевизийн мэдээллийн хөтөлбөрөөр нам, эвсэл, нэр дэвшигчдийн талаарх мэдээг хоногт 5 минутаас хэтрүүлсэн эсэх:**

- УБ хотын арилжааны 3 телевиз, орон нутгийн 1 телевизээр хэтрэлт бүртгэгдсэн.

Хүснэгт 6. Мэдээний 5 минутын хэтрэлт бүртгэгдсэн байдал.

№	Огноо	Хэтрэлт бүртгэгдсэн тоо	Хэтрэлт бүртгэгдсэн радио, телевиз	Тайлбар м
1	06-р сарын 10	УБ- 2 ТВ	Айст Глобал ТВ News Channel	35 мин 7 мин
	06-р сарын 14, 15-ны өдөр	УБ-1 ТВ Орон нутгийн 1 ТВ	MNC ТВ4	5 мин 5 мин
2	06-р сарын 11, 12, 13, 16-ны өдрүүд	Хэтрэлт бүртгэгдээгүй	-	-

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа радиогийн хувьд хэтрэлт бүртгэгдээгүй.

- **Жич:** Нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээ хоногт 5 минутаас хэтрэхгүй байх хуулийн 46.14 дахь заалтын тухайд: Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журмын 4.19-т заасны дагуу хуулийн 46.14 дэх заалттай холбоотой гомдол, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтнаас гаргасан хүсэлтийн дагуу холбогдох баримт мэдээллийг хянан үзнэ гэж заасан.

Иймд тус хорооны хяналт, мониторингд мэдээний 5 минут хэтрүүлсэн гэж бүртгэгдсэн тохиолдолд радио, телевизүүдэд хууль тогтоомж зөрчихөөс урьдчилан сэргийлэх үүднээс тухайн радио, телевизэд мэдэгдэж, зөвлөж, анхааруулах арга хэмжээ авч ажиллаж байна.

5. **Нам, эвслийн дарга, нэр дэвшигч оролцсон сурталчилгааны бус нэвтрүүлэг, хөтөлбөр, ярилцлага нэвтрүүлсэн эсэх:**

- Сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал нам, эвслийн дарга, нэр дэвшигч оролцсон, энэ хуульд зөвшөөрснөөс бусад хэлбэрийн бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, ярилцлага нэвтрүүлэхийг хориглосон. (Хуулийн 48.10)

5.1. **Нам, эвслийн дарга, нэр дэвшигч оролцсон, яриа өгсөн нэвтрүүлгээр бүртгэгдсэн.**

Хүснэгт 7. Телевизүүдээр нам, эвслийн дарга, нэр дэвшигч оролцсон, яриа өгсөн нэвтрүүлгийн бүртгэл

№	Бүртгэгдсэн тоо	Нэвтрүүлэг бүртгэгдсэн телевиз	Тайлбар
2	УБ арилжааны 12 ТВ	Movimax (5 эрдэнэ), Монгол ТВ1+, Авто, ТВ3, Айтс Глобал Бидний цөөхөн монголчууд Масс ТВ, Мянгат малчин Суваг 1, Эко,Хөгжил, MNC	“Заншлын хэлхээ”- танин мэдэхүйн нэвтрүүлэг,“Мандалын хурд 2023”, Улс төрийн задлан,Эрэн сурвалжлагч Дулаан намар тоглолт , УИХ-ын чуулган,“Зоригтын цаг”, “Хүүхэд 1-рт хөтөлбөр” “Монголын баялаг 330”-ёс заншлын нэвтрүүлэг, “Сайхан дууны түүх” зэрэг нэвтрүүлгийн дундуур нэр дэвшигч яриа өгсөн, нэр дэвшигчийн дуулсан дуу нэвтрүүлэг дундуур нэвтрүүлсэн гэж мониторингд бүртгэгдсэн. Анхааруулсны дагуу зөрчил дахин бүртгэгдээгүй.
	УБ арилжааны 2 ТВ	News channel, Гандан	Хүнсний хувьсгал нэвтрүүлгээс гадна Монгол уламжлал, Ярилцах цаг зэрэг нэвтрүүлэг нэвтрүүлсэн. Сонгуулийн сурталчилгааны бус нэвтрүүлэгт нэр дэвшигч яриа өгсөн. Дээрхийн адил анхааруулж, зөвлөмж хүргүүлсэн боловч давтагдсан тул Хууль, журамд заасны дагуу албан ёсны сануулах арга хэмжээ авч байна
3	Орон нутгийн 7 ТВ	Орхон-ТВ24, Мэдээллийн бирж Дорнод-D1 Дархан-Уул - ТВ4 Дорноговь- DS Ховд -Жаргалант ТВ, Орхон -Тусгал1	Түүхэн монгол сэдэвчилсэн нэвтрүүлэг, үхэл бол цэг биш таслал, марс хол биш баримтат кино, tegshee's podcast, “чинээлэг малчин бойжуулах төв” нэвтрүүлэг, “Дарханыг дархлагсад”, “Улаан шугам” баримтат кино зэрэг нэвтрүүлэг, кинонд нэр дэвшигчийн яриа орсон гэж тэмдэглэгдсэн. Анхааруулж, зөвлөмж өгсний дагуу дахин бүртгэгдээгүй.
21ТВ		Эдгээр телевизээр гарсан нэвтрүүлэг нь ерөнхийдөө өмнө хийгдсэн танин мэдэхүйн болон баримтат нэвтрүүлэг зэрэгт нэр дэвшигчийн яриа өгсөн хэсэг гарсан тул хууль тогтоомж зөрчихөөс сэргийлж, дээрх нэвтрүүлгүүдийг гаргахгүй байх, редакцадаа хяналт тавих талаар 1 удаа зөвлөмж, анхааруулга өгсөн. Дахин давтагдаагүй байна.	

Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизүүдээр зөрчил бүртгэгдээгүй.

5.2. Нийгмийн хариуцлагын үүднээс гаргаж байсан, өмнө хийсэн нэвтрүүлэг давтсанаас нэр дэвшигчийн яриа орсон нэвтрүүлэг бүртгэгдсэн:

Хүснэгт 8. Телевизүүдээр нэвтрүүлсэн нам, эвслийн дарга, нэр дэвшигч оролцсон, яриа өгсөн нэвтрүүлгийн бүртгэл - Хүнсний хувьсгал, нэр дэвшигчийн дуулсан дуу нэвтрүүлсэн

№	Телевизийн тоо	Нэвтрүүлэг бүртгэгдсэн ТВ	Зөрчлийн агуулга
1	УБ- 2ТВ	Улаанбаатар хотын арилжааны 2 телевиз	Зөвхөн Хүнсний хувьсгал, Эрүүл монгол хүн нэвтрүүлэг нэвтрүүлсэн нь нэвтрүүлэгт нэр дэвшигч яриа өгсөн гэж бүртгэгдсэн тул дахин давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгсний дагуу давтагдаагүй.
2	Орон нутаг- 4 ТВ	Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа 4 ТВ	Орон нутгийн 4 ТВ-р өмнө хийгдсэн Хүнсний хувьсгал, Тэрбум мод нэвтрүүлэг мөн нэр дэвшигчийн дуулсан дуу гарсан (Дорнод), дээрх нэвтрүүлэгт нэр дэвшигчийн яриа орсон гэж бүртгэгдсэн тул анхааруулж, зөвлөмж өгсөн
		6 телевиз	

- Арилжааны 2, орон нутгийн 4 телевизээр нийгмийн хариуцлагын үүднээс нэвтрүүлсэн Хүнсний хувьсгал, Тэрбум мод, Эрүүл монгол хүн үндэсний хөдөлгөөн зэрэг нэвтрүүлэг дундуур нэр дэвшигчид яриа өгсөн хэсэг гарсан нь хяналт, мониторингоор бүртгэгдсэн.
- Мөн нэр дэвшигчийн дуулсан дууг нэвтрүүлсэн орон нутгийн 2 телевиз бүртгэгдсэн. Гэвч эдгээр телевиз нь тухайн нэр дэвшигчийн нэр дэвшсэн тойрогт хөтөлбөрөө хүргэдэггүй тул аливаа дуу нэвтрүүлэхдээ нэр дэвшигч дуулсан эсэхийг хянаж байх талаар зөвлөсөн.

Авсан арга хэмжээ. Дээрх телевизүүдэд өмнө өгсөн эдгээр нэвтрүүлгүүдийг дахин гаргахгүй байх, шинээр бэлтгэн нэвтрүүлэх тохиолдолд нэр дэвшигч ороогүй байх, хууль, журамд зөвшөөрөгдсөн нэвтрүүлэг нэвтрүүлж, редакциядаа хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж өгч анхааруулсан.

- Түүнчлэн бүх телевизэд Хүнсний хувьсгал, Эрүүл монгол хүн, Тэрбум мод зэрэг бэлэн өгсөн нэвтрүүлгүүдийг гаргахгүй байх, шинээр бэлтгэн нэвтрүүлэх тохиолдолд хуульд заасан зөрчил гаргахгүй, редакциядаа хянаж ажиллах зөвлөмжийг мэйлээр хүргүүлсэн.

5.3. Улаанбаатар хотын радиогийн хөтөлбөрийн хяналт, мониторингийн дүн

Хүснэгт 9. Радиогоор нэвтрүүлсэн нам, эвслийн дарга, нэр дэвшигч оролцсон, яриа өгсөн нэвтрүүлгийн бүртгэл

№	Огноо	Зөрчилд бүртгэгдсэн тоо	Зөрчил бүртгэгдсэн радио, телевиз	Зөрчлийн агуулга
1	06-р сарын 10, 11	1	ФМ 98.9-Бизнес радио	“Баабар ингэж өгүүлэв”, “МУ-ын Ерөнхий сайд асан Амаржаргал оролцсон нийтлэл нэвтрүүлэг.
2	06-р сарын 12-16-ны өдрүүдэд	-	Зөрчилгүй	-

- Тус ФМ 98.9 радио нь эдийн засгийн чиглэлээр өмнө нь бэлтгэж байсан мэдээ, мэдээлэл нэвтрүүлэг тогтмол нэвтрүүлдэг радио бөгөөд эфирт өрөхдөө дутуу хянасан байна, дахин алдаа гарахгүй гэсэн тайлбар өгсөн. Зөвлөмж анхааруулга өгч ажиллав.

5.4. Радиогоор нэвтрүүлсэн нэр дэвшигчийн дуу нэвтрүүлсэн бүртгэл

Хүснэгт 9. Радиогоор нэр дэвшигчийн дуулсан дуу нэвтрүүлсэн бүртгэл

№	Огноо	Дуу бүртгэгдсэн тоо	Зөрчил бүртгэгдсэн радио, телевиз	Зөрчлийн агуулга
1	06-р сарын 10-16	16	ФМ103.6, ФМ99.7, ФМ95.7, ФМ95.1, ФМ96.9, ФМ101.7, ФМ88.8, ФМ102.1, ФМ90.5, ФМ89.3, ФМ104.5, ФМ98.9, ФМ96.3, ФМ92.5, FM 89.7, FM 97.5	Нэр дэвшигч С.Жавхлангийн дуулсан дуунууд, Ж.Баясгалангийн дуулсан дуунууд Т.Бат-Оргилын дуу Ш.Бат-Эрдэнэ дуулсан дуу

Сурталчилгааны эхний 7 хоногт дээрх 16 радиогийн хувьд нэр дэвшигчдийн дуу бүртгэгдсэн. Нэр дэвшигчдийн нэр дэвшсэн тойргуудад хөтөлбөр нь цацагддаггүй тул тусгаар анхааруулж, зөвлөмж өгсөн.

МЭТГЭЛЦЭЭНИЙ НЭВТРҮҮЛЭГ НЭВТРҮҮЛСЭН БАЙДАЛ

Сонгуулийн сурталчилгааны эхний 7 хоног


МҮОНТ

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сурталчилгааны хугацаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар олон нийтийн радио, телевизэд үүрэг болгосон өмнөх сонгуулиудаас ялгаатай орсон заалтын тухайд **МҮОНРТ нь сонгуулийн сурталчилгаанд хуваарилсан нийт цагтай тэнцүү хэмжээний цагийг мэтгэлцээний нэвтрүүлэгт хуваарилахаар заасан².**

Харилцаа холбооны зохицуулах хороонд МҮОНРТ-ээс ирүүлсэн сурталчилгааны болон мэтгэлцээний төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цагийн саналыг хянан үзэхэд сонгуульд оролцож байгаа 21 нам, эвсэл, 42 бие даан нэр дэвшигчдэд ижил нөхцөл, тэгш боломж олгохын тулд эфирийн нийт цагийн 71%-ийг сонгуулийн сурталчилгаа болон мэтгэлцээний нэвтрүүлэгт хуваарилсан байна.

² МУИХ-ын Сонгуулийн тухай хуулийн 46.4. Харилцаа холбооны зохицуулах хороо олон нийтийн радио, телевизээс ирүүлсэн сурталчилгааны болон мэтгэлцээний төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цагийн талаарх саналыг хянан үзэж, сурталчилгааны болон мэтгэлцээний нэвтрүүлгийн хуваарь, цагийг тэнцүү байхаар тооцож, сурталчилгаа эхлэхээс 7-оос доошгүй хоногийн өмнө батална.

MNB НЭГ ХОНОГИЙН ЭФИРИЙН ЦАГ



МУ-ын Сонгуулийн тухай хуулийн 46.4-д заасны дагуу МҮОНРТ нь сонгуулийн сурталчилгааны болон мэтгэлцээний нэвтрүүлгийн цагийг нийт сонгуулийн сурталчилгааны 17 хоногийн хугацаанд тэнцүү байхаар тооцож, тус бүр 6120 минутыг хуваарилж олгосон байна.

МҮОНРТ нь мэтгэлцээний нэвтрүүлгийн хуваарь, цагийг гаргахдаа Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Монгол улсын их хурлын 2024 оны ээлжит сонгуулийн мэтгэлцээний дэгийн дагуу, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журамд нийцүүлэн хуваарилсан байна.

Мэтгэлцээний цаг хуваарилсан аргачлал



Мэтгэлцээний төлбөргүй нэвтрүүлгийн цаг хуваарилахдаа Монгол Улсын Сонгуулийн тухай хуулийн 46.3 болон 46.12-т заасны дагуу сонгуульд оролцогч бүх нам, эвсэл, нэр дэвшигчид тэгш хандах зарчмыг баримталсан.



1 Мэтгэлцээний дэгийн саналыг хэлэлцүүлж, батлах.

МҮОНРТ нь мэтгэлцээний дэгийн саналыг нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдэд 2024.6.02-ны өдөр хэлэлцүүлж, эцэслэн баталсан.

2 Мэтгэлцэх тэгш боломж олгох

21 нам, эвсэл, 42 бие даан нэр дэвшигчид хоорондоо таарч мэтгэлцэх нөхцөлийг баримтлаж "санамсаргүй функц" ашиглан хуваарилсан байна.

3 Мэтгэлцээнд оролцогчид

1 дугаарт 4 нам, эвсэл, 1 бие даан эвсэл, нийт 5 мэтгэлцэгч оролцохоор, эсхүл 5 нам, эвсэл оролцох.

Нам, эвслийн мэтгэлцээний нэвтрүүлгийн ноогдсон цагт **аль нэр дэвшигч орохыг тухайн нам, эвсэл шийдэх.**

4 Нийт 51 мэтгэлцээн хэлэлцүүлж, батлах.

Нийт сурталчилгааны 17 хоногт 120 минутаар, өдөр бүр 2-4 удаа нийт **51 дугаар** бэлтгэн шууд дамжуулна.

-Нэвтрүүлэгт хуваарийн дагуу ирж оролцоогүй бол **цагийг нөхөн олгохгүй.**

Харилцаа холбооны зохицуулах хороо нь МУИХ-ын Сонгуулийн тухай хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд Монголын Үндэсний олон нийтийн радио, телевиз (МҮОНРТ)-ээс ирүүлсэн сонгуулийн сурталчилгааны болон мэтгэлцээний төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цагийн санал, уг саналыг гаргахад баримталсан аргачлал, мэтгэлцээний нэвтрүүлгийн дэгийг хүлээн авч хууль, журамд заасан зарчимд нийцэж байгаа эсэхийг хянан үзэж, тус Хорооны 2024 оны 06-р сарын 02-ны өдрийн Хуралдааны 129 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цаг, хоёрдугаар хавсралтаар олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх мэтгэлцээний төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цагийг тус тус батлан гаргасан.

Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 6-р сарын 06-ны өдрийн Хуралдаанаар нэр дэвшигчдийг дахин бүртгэх асуудлыг хэлэлцэж, нийт 92 хүнийг нэр дэвшигчээр нэмж бүртгэх

шийдвэр гарсантай холбоотойгоор МҮОНРТ-ээс ирүүлсэн Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны болон мэтгэлцээний төлбөргүй нэвтрүүлгийн дээрх батлагдсан хуваарь цагт Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны 6-р сарын 08-ны өдрийн 130 тоот тогтоолын хавсралтаар нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Тус хорооноос хийгдэж байгаа хяналт, мониторингийн дүнгээр МҮОНРТ нь мэтгэлцээний нэвтрүүлгийг дээрх батлагдсан хуваарь, цагийн дагуу нэвтрүүлсэн эсэхийг хянаж үзэхэд:

№	Огноо	Мэтгэлцээн нэвтрүүлсэн тоо	Нийт цаг	Хуваарийн дагуу нэвтрүүлсэн эсэх
1	06-р сарын 10-16	23 мэтгэлцээн	34 цаг 30 минутын мэтгэлцээн	Бүх мэтгэлцээн батлагдсан хуваарийн дагуу нэвтрүүлсэн

МҮОНРТ-ийн MNB сувгаар 6-р сарын 10-16-ны өдрүүдэд 23 удаагийн мэтгэлцээний нэвтрүүлэг нэвтрүүлэх хуваарь, цаг төлөвлөсөн ба бүгд хуваарийн дагуу нэвтрүүлсэн байна. Төлөвлөсөн нийт 23 удаагийн нэвтрүүлгээр 46 цагийн мэтгэлцээний нэвтрүүлэг нэвтрүүлэхээс 34 цаг 30 минутын мэтгэлцээн нэвтрүүлсэн байна. Мэтгэлцээнд 17 нам, 2 эвслийн 95 нэр дэвшигч (давхардсан тоогоор 157 нэр дэвшигч) оролцсон бол 6 бие даан нэр дэвшигч мэтгэлцжээ.

Харин хуваарилагдсан өдөр, цагтаа Иргэний хөдөлгөөний нам 5 удаа, Монголын либерал ардчилсан нам 4 удаа, Эх орончдын нэгдсэн нам 1 удаа, Иргэдийн оролцооны нам 1 удаа, Монгол ардын нам 1 удаа, Бүгд найрамдах нам 1 удаа, Шинэ нэгдсэн эвсэл 1 удаа төлөөлөл оролцоогүй бол 9 бие даан нэр дэвшигч мэтгэлцээнд оролцоогүй байна.

Монголын мэдээ сувгаар мэтгэлцээний нэвтрүүлгүүдийг давтан нэвтрүүлж байна.

МҮОНРТ-ээс бусад телевизээр мэтгэлцээн нэвтрүүлсэн тухайд:

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сурталчилгааны хугацаанд зөвхөн МҮОНРТ бус бусад телевизээр сонгогчдын мэдэх эрхийг хангах үүднээс мэтгэлцээн нэвтрүүлж байгаа нь сайшаалтай байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.17-дэх заалтад Улс төрийн мэтгэлцээний нэвтрүүлэг, хөтөлбөр нь сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэгт хамаарахгүй бөгөөд уг нэвтрүүлэгт нэг намын бус, түүнчлэн бие даагч хэд хэдэн нэр дэвшигч, эсхүл өөр өөр нам, эвслийн төлөөлөл оролцсон байх шаардлага тавьсан.

Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журмын 4.11-т заасны дагуу улс төрийн мэтгэлцээний нэвтрүүлэг нэвтрүүлэхдээ мэтгэлцээний тогтсон дэгтэй байх, оролцогчдын нэрсийг тэдгээрийн нэр дэвшүүлсэн нэрийг, нам, эвслийн нэрийн хамт тодорхой илэрхийлэх талаар заасан.

Иймд телевизүүдээр нэвтрүүлсэн мэтгэлцээний нэвтрүүлэг нь дээрх хууль, журамд нийцсэн эсэхийг хянаж, тайлан мэдээ гаргалаа.

№	Огноо	Мэтгэлцээн нэвтрүүлсэн ТВ тоо	Нийт мэтгэлцээний нэвтрүүлгийн тоо	Мэтгэлцээн нэвтрүүлсэн телевизийн нэрс
1	06-р сарын 10	2ТВ	2 мэтгэлцээн	Тэнгэр ТВ, Парламент,
2	06-р сарын 11	3 ТВ	4 мэтгэлцээн	Тэнгэр ТВ, Соён гэгээрүүлэгч, Парламент
3	06-р сарын 12	2ТВ	3 мэтгэлцээн	Тэнгэр ТВ, Парламент
4	06-р сарын 13	3ТВ	4 мэтгэлцээн	Тэнгэр ТВ, ТВ8, Парламент
5	06-р сарын 14	3ТВ	4 мэтгэлцээн	Тэнгэр ТВ, ТВ8, Парламент
6	06-р сарын 15	4ТВ	6 мэтгэлцээн	Тэнгэр ТВ- 2 ТВ8, Соён гэгээрүүлэгч, Парламент
7	06-р сарын 16	4ТВ	5 мэтгэлцээн	Тэнгэр ТВ- 2 ТВ8, Соён гэгээрүүлэгч, Парламент
	Нийт	4ТВ	28 удаагийн мэтгэлцээн	

Мониторингоор 6-р сарын 10-16-ны өдрүүдэд Парламент, Тэнгэр, Соён гэгээрүүлэгч, ТВ8 телевизүүдээр 28 удаагийн нийт 39 цаг 28 минутын мэтгэлцээний нэвтрүүлэг нэвтрүүлсэн байна. Тэнгэр, ТВ8 телевизүүд мэтгэлцээний нэвтрүүлгээ бүрэн дохионы хэлтэй нэвтрүүлсэн нь 28 цаг 29 минутын нэвтрүүлэг байна.

Эдгээрийн 4 телевизээр нэвтрүүлсэн мэтгэлцээний нэвтрүүлгийн 15 дугаар буюу 21 цаг 21 минутын нэвтрүүлэг нь шинэ дугаар бол бусад 13 дугаарын 18 цагийн нэвтрүүлэг нь давталтын дугаарууд байна. Соён гэгээрүүлэгч телевизийн мэтгэлцээний нэвтрүүлэг нь 2-4 оролцогчтой, ТВ8 телевизийнх 3 оролцогчтой бол Тэнгэр телевизийн мэтгэлцээний нэвтрүүлэг нь тогтмол 6 оролцогчтой байна. Эдгээр телевизүүд нь нэвтрүүлэгтээ өөр, өөр нам, эвсэл түүнчлэн бие даан нэр дэвшигч оролцуулж байгаа нь оролцогчдын төлөөллийн тэгш байдлыг хангаж байна гэж үзэж байна.

СОНГОГЧДЫН БОЛОВСРОЛД ЗОРИУЛСАН НЭВТРҮҮЛЭГ, СУРТАЛЧИЛГАА

НЭВТРҮҮЛСЭН БАЙДАЛ

Сонгуулийн сурталчилгааны эхний 7 хоногийн тайлан

Хамрах хугацаа: 6-р сарын 10-16-ны өдрүүд

Радио, телевиз нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.15-т заасны дагуу сонгогчдын боловсролд зориулсан мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг, хөтөлбөр бэлтгэж түгээх үүрэгтэй.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос радио, телевизүүдээр нэвтрүүлсэн сонгогчдын боловсролын нэвтрүүлэг, сонгогчдын боловсролд зориулсан богино хэмжээний мэдээлэл, сурталчилгаа хэрхэн нэвтрүүлж байгаа талаар хяналт, мониторинг хийж, тайлан мэдээг гаргаж байна.

Сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг

Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн эхний долоо хоног буюу 6-р сарын 10-16 өдрүүдэд 7 телевиз нийт 18 цаг 51 минутын сонгогчдын боловсролд зориулсан бие даасан нэвтрүүлэг бэлтгэн нэвтрүүлсэн байна.

Үүнийг нэвтрүүлсэн телевиз тус бүрээр авч үзвэл:

Телевизийн нэр	Нэвтрүүлсэн цаг
MNB	6:33:09
MNB Монголын мэдээ	1:39:50
ЕТВ	0:29:51
Өлзий ТВ	0:40:58
Стар ТВ	0:49:03
ТВ9	1:11:41
Тэнгэр	7:27:14
Нийт	18:51:46

Эдгээрийн 4 цаг 38 минутын нэвтрүүлгийг дохионы хэлтэй нэвтрүүлсэн нь олон нийтийн телевизийн MNB болон Монголын мэдээ сувгуудаар гарчээ.

Сонгогчдын боловсролд зориулсан богино хэмжээний сурталчилгаа

Телевизүүд сонгогчдын боловсролд зориулсан богино хэмжээний мэдээлэл сурталчилгааг идэвхтэй нэвтрүүлж байна. Тухайлбал, Улаанбаатар хотын **37, орон нутгийн 24 телевизээр сонгогчдын боловсролд зориулсан богино хэмжээний мэдээлэл, сурталчилгааг** нэвтрүүлсэн нь **нийт 3016 удаа 76 цаг** гаруй хугацаа зарцуулжээ.

UBS, Мянгат малчин, Тэнгэр, ТВ8, Гандан, National times news, Орхон аймгийн etv, Тусгал1, Хэнтий аймгийн Өндөрхаан телевизүүд нь сонгогчдын боловсролд зориулсан сурталчилгааг хамгийн олон нэвтрүүлсэн буюу 2 цагаас дээш хугацаатай нэвтрүүлсэн байна.

Эдгээр нь бүгд Сонгуулийн ерөнхий хорооноос бэлтгэн телевизүүдэд хүргэсэн 5 төрлийн богино шторк хэлбэрийн сурталчилгаа байна.

Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийг бүртгэх бүртгэхээс татгалзах журмын 4.12-т зааснаар Телевиз нь хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг, мэдээ, мэдээлэл бэлтгэн хүргэхдээ хадмал тайлбар, эсхүл дохионы хэлний орчуулгатай байгаа эсэхэд мөн хяналт тавьж байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос сонгогчдын боловсролд зориулан бэлтгэсэн энэхүү 5 төрлийн сурталчилгааны 1 нь дохионы хэлтэй, 1 нь бичгэн тайлбартай бол 2 нь дохионы хэл болон бичгэн тайлбартай байна.